210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,984,044.00	4,387,415.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	716,000.00
210102	Нэмэгдэл		716,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,860,000.00	1,491,415.00
210402	Тээвэр, шатахуун	1,530,000.00	1,481,415.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	330,000.00	10,000.00
2105	Нормативт зардал	-	330,000.00
210502	Хоол, хүнс		330,000.00
2107	Томилолт, зочны зардал	160,000.00	-
210702	Дотоод албан томилолт	160,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,964,044.00	1,850,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,964,044.00	1,850,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,984,044.00	4,387,415.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,984,044.00	4,387,415.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,000,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,984,044.00	3,387,415.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хэрэгжүүлэх, иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон нийгмийн үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тайлант онд “Хуулиар хүлээлгэсэн нийтлэг бүрэн эрх үүргээ хэрэгжүүлэхийн төлөө бүх хүчин чадал, ур чадвар, хуримтлуулсан туршлагаа дайчлан чин шударгаар ажиллан, тэргүүний эвсэг, шилдэг хамт олон бүрдүүлэх” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгын хүрээнд: “Иргэний нийгэм, төрийн байгууллагын түншлэл, ил тод байдал, хариуцлагын тогтолцоо, нь хуулиа дээдэлсэн, төрийн үйлчилгээ нь нээлттэй, шуурхай, хүнд суртал, чирэгдэлгүй, ёс зүйтэй, ажил хэрэгч, иргэдийн санал хүсэлтийг хүндэтгэсэн байх зорилт дэвшүүлсэн байна

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч 2023 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 02 дугаар тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг байна.

Тус төсвийн төвлөрүүлэн захирагчийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 76.3 сая төгрөгөөр буюу 5.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	117,238.2	148,584.7	31,346.5
Авлага	152,639.4	173,407.9	20,768.5
Урьдчилж гарсан зардал	0	0	0
Бараа материал	31,037.7	38,906.7	7,869.0
Үндсэн хөрөнгө	1,182,183.2	1,198,540.1	16,356.9
Нийт хөрөнгө	1,483,098.5	1,559,439.4	76,340.9
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,483,098.5	1,559,439.4	76,340.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,483,098.5	1,559,439.4	76,340.9

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 148.6 сая төгрөг болж, өмнөх оноос 31.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+),
			Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	117.2	148.6	31.4
Төгрөг	117.2	148.6	31.4
Төрийн сангийн харилцах	117.2	148.6	31.4
Арилжааны банк дахь харилцах			
Дүн	117.2	148.6	31.4

Эх сурвалж: Аудитын судалгаа.

Оны эцэст мөнгөн хөрөнгө 148.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч оны эхнээс 31.3 сая төгрөгөөр өссөн байна. Оны эцэст Төсвийн ерөнхий орлогын дансанд 44.4 сая төгрөг, ОНХСанд 45.1 сая төгрөг, Сум хөгжүүлэг сангийн дансанд 59.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Мөнгөн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 173.4 сая төгрөг болж, өмнөх оноос 20.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	-	-	-
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-	-
Зээлийн хүүгийн авлага	6.3	10.6	4.3
Байгууллагаас авах авлага	0.5	0.3	(0.2)
Хувь хүмүүсээс авах авлага	1.1	10.0	8.9
Зээлийн авлага	144.7	152.5	7.8
Хувь хүмүүст олгосон зээл	144.7	152.5	7.8
Дүн	152.6	173.4	20.8

сурвалж: Аудитын судалгаа

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 20.8 сая төгрөгөөр өссөн бөгөөд байгууллагаас авах авлага 0.2 сая төгрөгөөр буурч, хувь хүмүүсээс авах авлага 8.9 сая төгрөгөөр, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн авлага 4.3 сая төгрөгөөр нэмэгдэж, сумын Хоршоо хөгжүүлэх сангийн авлага тайланд онд олгосон 7.8 сая төгрөгийн зээлийн хэмжээгээр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Авлага данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилж гарсан зардал дансанд өөрчлөлт ороогүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 38.9 сая төгрөг болж, өмнөх оноос 7.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	7.5	15.2	7.7
Эм боох материал	7.5	15.2	7.7
Бэлэн бүтээгдэхүүн	-	-	-
Хангамжийн материал	23.5	23.7	0.2
Бичиг хэргийн материал	-	-	-
Аж ахуйн материал	23.5	23.7	0.2
Сэлбэг хэрэгсэл	-	-	-
Түлш, шатах тослох материал	-	-	-
Хүнсний материал	-	-	-
Бусад хангамжийн материал	-	-	-
Мал амьтад	-	-	-

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дүн	31.0	38.9	7.9
------------	-------------	-------------	------------

Эх сурвалж: Аудитын судалгаа

ЗДТГ 22.3 сая төгрөгийн, ИТХ 1.4 сая төгрөгийн, Эмийн эргэлтийн сан 15.2 сая төгрөгийн нийтдээ 38.9 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Бараа материал данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө:

Бусад эргэлтийн хөрөнгө байхгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,198.5 сая төгрөг болж, өмнөх оноос 16.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	1,167.8	1,183.4	15.6
Барилга, байгууламж, орон сууц	576.7	552.6	(24.1)
Авто-тээврийн хэрэгсэл	6.0	3.9	(2.1)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	20.1	57.1	37.0
Тавилга, аж ахуйн эд хогшил	13.7	13.3	(0.4)
Зам, гүүрийн байгууламж	53.9	47.9	(6.0)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	-	-	-
Бусад үндсэн хөрөнгө	297.4	308.6	11.2
Дуусаагүй барилга, байгууламж	200.0	200.0	0
Ном	-	-	-
Биет бус хөрөнгө	14.4	15.1	0.7
Программ хангамж	3.0	3.7	0.7
Бусад биет бус хөрөнгө	11.4	11.4	0
Дүн	1,182.2	1,198.5	16.3

Эх сурвалж: Аудитын судалгаа

Үндсэн хөрөнгийн данс оны эхэнд 1,182.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба төсвийн хөрөнгөөр 0,7 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 95.3 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, аймгийн ИТХ-ын 2023 оны 03 дугаар сарын 23-ны 156 тоот тогтоолоор 48.3 сая төгрөгийн хөрөнгийг акталж, аймгийн ИТХ-ын 2023 оны 03 дугаар сарын 23-ны 149 тоот тогтоолоор 19.9 сая төгрөгийн УАЗ-390942017 маркийн фермер авто машиныг Хилийн цэргийн 0285 дугаар ангид шилжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

➤ Үндсэн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.7 Өр төлбөр

Өр төлбөр данс 2023 оны эхэн ба оны эцэст үлдэгдэлгүй байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Өглөг	-	-	-
Ажилчидтай холбогдсон өглөг	-	-	-
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-	-
Бусад өглөг	-	-	-
Байгууллагад төлөх өглөг	-	-	-
Хувь хүмүүст төлөх өглөг	-	-	-
Дүн	-	-	-

Эх сурвалж: Аудитын судалгаа

2023 онд өглөг гараагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- *Өглөг данстай холбоотой зөрчил гараагүй.*

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,559.4 сая төгрөг болж, өмнөх оноос 76.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,120.0	1,120.0	0
Хуримтлагдсан үр дүн	363.1	439.4	76.3
Өмнөх үеийн үр дүн	3,619.1	(191.6)	(3,427.5)
Тайлант үеийн үр дүн	(3,810.7)	76.3	3,887.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	554.7	554.7	0
Дүн	1,483.1	1,559.4	76.3

/ сая төгрөгөөр/

Эх сурвалж: Аудитын судалгаа

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,559.4 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 76.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Алтанцөгц сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1.041.7 сая төгрөгөөр, төсвийн зарлагыг 1.041.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тус сумын төсвийг 12.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1,053.8 сая төгрөгөөр баталсан байна. Төсвийн тодотголоор 12.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1,195.5 сая төгрөгөөр баталсан байна.

Нийт зардлын 936.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 190.7 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 68.0 сая төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Алтанцөгц сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 онд гүйцэтгэлээр нийтдээ 1,135.1 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого бүрдүүлсэн байна. Үүнд: орон нутгийн төсвийн орлогоос 914.6 сая төгрөгийн санхүүжилт, Орон нутгийн хөгжлийн сангаас 162.3 сая төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 58.2 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 57.8 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлагын эргэн төлөлтийн орлого байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,127.6 сая төгрөг буюу 94.3 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилт, тасарсан орлого, мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй холбоотой байна. Татварын орлого нь төрийн сангийн зарлагын гүйлгээг 12 дугаар сарын 25-ны өдрөөр тасалбар болгож хааснаар дутуу биелэгдсэн байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Аймгийн ИТХ-ын 2022 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 132 дугаар тогтоолоор Алтанцөгц сумын 2023 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 269.6 сая төгрөгөөр баталж, аймгийн ИТХ-ын хуралдааны “2023 оны төсөвт тодотгол хийх тухай” 2023 оны 192 дугаар тодотголоор 278.6 сая төгрөгөөр буюу 9.0 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 62 дугаар хуралдааны тогтоолоор 2023 орлогын төлөвлөгөөг 278.6 сая төгрөгөөр хэвээр нь баталжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогод 287.1 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 8.5 сая төгрөгөөр буюу 3.0 хувиар давуулан биелүүлсэн байна.

<i>Хүснэгт №2 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл</i>			<i>/сая төгрөг/</i>	
<u>Үзүүлэлт</u>	<u>Төлөвлөгөө</u>	<u>Гүйцэтгэл</u>	<u>Өсөлт/+, бууралт -/</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
I.Татварын орлого	271.3	276.9	5.6	102.0
II.Татварын бус орлого	7.3	10.2	2.9	1.0
Нийт дүн	278.6	287.1	8.5	103.0

Орон нутгийн татварын орлого нь 271.3 сая төгрөгөөр төлөвлөгдөж, гүйцэтгэлээр 276.9 сая төгрөгөөр буюу 5.6 сая төгрөгөөр, татварын бус орлого нь 7.3 сая төгрөгөөр төлөвлөгдөж, гүйцэтгэлээр 10.2 сая төгрөгөөр буюу 2.9 сая төгрөгөөр тус тус давуулсан биелүүлсэн байна.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд цалин хөлс түүнтэй адилтгах орлого 45.9 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 1.0 сая төгрөгөөр, татварын бус орлого буюу бусад нэр заагдаагүй орлого 3.6 сая төгрөгөөр давж биелэгдэн, малд ногдуулах албан татвар төлөвлөгдөөгүй боловч 7.5 сая төгрөгийн орлого оруулсан нь төлөвлөгөөний биелэлтэд голлон нөлөөлсөн байна.

Хүү торгуулийн орлого 0.6 сая төгрөгөөр, иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогоос суутгасан албан татвар буюу хөрөнгийн орлого 0.4 сая төгрөгөөр, үйл ажиллагааны орлогын албан татвар 21.9 сая төгрөгөөр, бууны албан татвар 1.4 сая төгрөгөөр, газрын төлбөр 9.9 сая төгрөгөөр, ойгоос мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр 0.3 сая төгрөгөөр, агнуурын нөөцийн төлбөр 8.7 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж 4.9 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн татвар 1.3 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 0.2 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 20.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба 287.1 сая төгрөгийн татварын орлого төвлөрүүлж, оны эцэст 44.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт №3 Төсвийн байгууллагуудын 2023 оны төсвийн зарлагын гүйцэтгэл:

/сая төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	ИТХурал	85.4	68.2	-17.2
2	ЗДТГазар	521.4	517.7	-3.7
3	Ерөнхий боловсролын сургууль	201.2	200.8	-0.4
	Хүүхдийн цэцэрлэг	60.7	60.7	-0.04
4	Хүүхдийн цэцэрлэг-2	7.0	6.8	- 0.2
5	Соёлын төв	31.1	30.8	-0.3
6	Эрүүл мэндийн төв	29.9	29.5	-0.5
7	ОНХСан	190.7	146.2	-44.4
8	СХСан	68.0	66.9	-1.2
	Нийт дүн	1,195.5	1,127.6	-67.9

Сумын ЗДТГ, ИТХ-ын төсвийн гүйцэтгэл төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан төлөвлөлттэй холбоотой байна. ОНХСангийн төсвийн гүйцэтгэлд 7 төсөл хөтөлбөрийн ажил дутуу хийгдсэн нь нөлөөлсөн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 онд 4.4 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байна. Үүнд: дээд шатны төсвийн захирагчаас нийт 1.0 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос 3.4 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авч цалин хөлс нэмэгдэл урамшил зардалд 0.7 сая тээвэр шатахууны зардалд 1.5 сая, норматив зардалд 0.3 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 1.9 сая нийт 2.2 сая төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого ороогүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах БӨА-2024/02/НА-СТА-ТТЗ

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркебулан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/56 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Бугат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 978.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 14.7 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан ба алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгасан.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийтдээ 4,447.9 сая төгрөгийн 174 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 10,499.3 сая төгрөгийн 90 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 1,372.4 сая төгрөгийн 38 мөнгөн гүйлгээг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

Аудитын илрүүлэлт:

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Алтанцөгц сумын ЗДТГ цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 53.2 сая төгрөгийн 1 мөнгөн гүйлгээг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулаагүй байна.

Алтанцөгц сумын ИТХ шилэн дансанд мэдээлээгүй цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 13,575.5 мянган төгрөгийн 2 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулахтай холбоотой 1900.0 мянган төгрөг 7 шийдвэрийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа зөрчилтэй суудал гараагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар 1 заалттай зөвлөмж өгсөн байна. Зөрчлийг арилгаж зөвлөмжийн биелэлтийг Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газрын 2023.10.05 №2/135 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	0	1	0	100
Нийт дүн	1	0	1	0	100

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил гараагүй боловч аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар бүх сумын Засаг дарга нарт малын татварын төлөвлөлт, бүрдүүлэлтийн талаар “Малын татвараас орох орлогыг үндэслэлтэй төлөвлөж, сумын ИТХ-аар батлуулж, орлогыг сумын төсвийн орлогод бүрэн төвлөрүүлж ажиллах” зөвлөмж өгсөн байна.

Алтанцөгц сумын ИТХурлын тогтоолоор малын татварын төлөвлөгөөг батлаагүй, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Алтанцөгц сумын ИТХурлын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 54 тоот тогтоолоор цаг агаарын байдал хүндэрч, мал зударч байгаа ба малчдын амжиргааг дэмжих зорилгоор 2023 оны малын хөлийн татвараас түр чөлөөлсөн шийдвэр гасгасан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах зүйл байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлантай холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллагыг түүвэрт хамруулсан, 2 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг-1, Хүүхдийн цэцэрлэг-2, Соёлын төв, Эрүүл мэндийн төвд орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтийг нэгтгэлд хамруулсан байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 286.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 15.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, 8 заалттай 256.6 сая төгрөгийн зөвлөмж, 14.3 сая төгрөгийн зөрчилд залруулга хийсэн байна.

Хүснэгт 4: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл /сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сумын ИТХурал	4	23.8					1	15.5	3	8.3
2	Сумын ЗДТГазар	6	183.7	2	14.3					4	169.4
3	ХХС	1	78.9							1	78.9
Нийт дүн		11	286.4	2	14.3			1	15.5	8	256.6

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дүн													
-----	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								